



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Баянцагаан сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БНА-2020/16/СТА-ТТЗ

<p>Баянхонгор 2020 он</p>	<p>Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер: А.Цээням Утас: 88089024 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn Аудитор: П.Амаржаргал Утас: 88106992 Цахим хаяг: amaraa_802002@yahoo.com Цахим хуудас: www.audit.mn</p>
-------------------------------	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	2
2. Аудитын тайлан.....	4
2.1. Оршил.....	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	4
2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, АРГА зүй, шалгуур үзүүлэлт.....	4
2.4. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.5. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	5
2.6. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	5
2.7. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	6
2.8 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт	6
2.8.1 Мөнгөн хөрөнгө	6
2.8.2 Авлага	7
2.8.3 Бараа материал	7
2.8.7 Үндсэн хөрөнгө	7
2.8.8 Өр төлбөр	8
2.8.9 Засгийн газрын хувь оролцоо.....	8
2.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	9
2.10. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	10
2.11. Шилэн дансны мэдээлэл	11
2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	11
2.13. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	11
3. Менежментийн захидал	12
3.1 БАЙГУУЛЛАГЫН ҮНДСЭН АЖИЛЛАГААТАЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ.....	12
4. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан	13
4.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	13
4.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан.....	14
4.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	17
4.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	20
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	21
4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	24
5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	26

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч

1. Аудитын гэрчилгээ



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584
E-mail: bayankhongor@audit.gov.mn

2020.03.24 № 1/362

танай _____-ны № _____-г

Г Аудитын гэрчилгээ Г

Г БАЯНЦАГААН СУМЫН ЗАСАГ Г
ДАРГА Н.ШАГДАРСУРЭН
ТАНАА

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2, 8.9.3-д заасны дагуу Баянцагаан сумын Засаг даргын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Баянцагаан сумын Засаг даргын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баянцагаан сумын Засаг даргын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын

D:\бичиг хэрэг 2020-Албан тоот А4\
005020292

хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг хариуцлага

Баянцагаан сумын Засаг дарга нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.МӨНХБАТ

D:\бичиг хэрэг 2020-Албан тоот А4\

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Баянцагаан сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн төвлөрүүлэн захирагч Н.Шагдарсүрэн танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Баянцагаан сумын Засаг даргын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянцагаан сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 03 дугаар сарын 13-аас 2020 оны 03 дугаар сарын 18-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 03 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Амаржаргал гүйцэтгэв.

Баянцагаан сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 03 дугаар сарын 09-ны өдрийн 1/85 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэн, шат шатны чанарын хяналт хийж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитыг Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болгож, батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлэв.

2.4. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Баянцагаан сумын Засаг даргын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох стандарт, журмын дагуу шинэчлэгдсэн байна.

Баянцагаан сумын Засаг даргын үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь Баянцагаан сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын 2019 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

Төрийн аудитын байгууллагаас эрх асуудлын хүрээний байгууллагад санхүүгийн тайлангийн аудит хийсэн хэлбэрийг дараах хүснэгтээр үзүүлэв.

№	Байгууллагын ангилал	Санхүүгийн тайлангийн аудит хийсэн хэлбэр				
		Санал дүгнэлт гаргасан	Түүвэрлэсэн	Итгэл үзүүлсэн	Гэрээгээр хийлгэсэн	Аудитад хамрагдаагүй
1	Төсвийн шууд захирагч	3	4	-	2	-
	Дүн	3	4	-	2	-

2.5. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Баянцагаан сумын Засаг даргын бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Баянцагаан сумын Засаг дарга санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн "Засгийн газрын санхүүгийн "Э-тайлан"" программ хангамж ашигладаг байна.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 5 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 5 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.6. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшнийг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг 2018 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 2425,0 сая төгрөгийн 1.0 хувь буюу 24,2 сая төгрөгөөр тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2019 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 2519,5 сая төгрөгийн 1.0 хувь буюу 25,2 сая төгрөгөөр тооцсон нь улсын төсвөөс санхүүждэг төсөвт байгууллагын хувьд байгууллагын нийт зардлыг суурь үзүүлэлт болгон сонгох нь зохимжтой гэж үзсэнтэй холбоотой юм.

2.7. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 5 төсвийн байгууллага, 2 тусгайн сангийн нийт 7 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 7 байгууллага аудитад хамрагдсан байна.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд “Зөрчилгүй” 3, дүгнэлт өгч, Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Соёлын төв, Орон нутгийн хөгжлийн сан, Сум хөгжүүлэх сангийн тайланг түүвэрт хамруулж санал дүгнэлт өгөөгүй байна.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн залруулга

Тус төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар залруулга хийгдээгүй байна.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитын илрүүлэлт:

- Аудитад хамрагдсан төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 37,8 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 1,3 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 36,3 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага, 0,2 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгсөн байна. / Зөрчлийн дэлгэрэнгүй жагсаалтыг хавсралтаар гаргасан болно./

- Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд илэрсэн залруулагдаагүй алдаа зөрчил

- . Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд залруулагдаагүй дараах 37,8 сая төгрөгийн алдаа зөрчил илэрлээ./зөрчлийн нэгтгэлийг хавсралтаар харуулсан болно/ Үүнд:

Сая төгрөгөөр

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн
1.Сумын ЗДТГ	1	36,3	0	0	1	36,3	0	0
2.СХС	1	0,3	1	0,3	0	0	0	0
3.ЕБС	2	1,1	1	0,9	0	0	1	0,2
4.ИТХ	1	0,09	1	0,09	0	0	0	0
ДҮН	5	37,8	3	1,3	1	36,3	1	0,2

2.8 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

2.8.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 99,7 сая, эцсийн үлдэгдэл 165,8 сая төгрөг болж, 66,1 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Касст байгаа бэлэн мөнгө	-	-	-	-
Төрийн сангийн дансанд байгаа бэлэн мөнгө	99,7	165,8	66,1	100,0
Замд яваа мөнгөн хөрөнгө	-	-	-	-
Хадгаламж	-	-	-	-
Дүн	99,7	165,8	66,1	100,0

Эх сурвалж: Баянцагаан сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 165,8 сая төгрөг төрийн сангийн орон нутгийн ерөнхий орлогын дансанд 68,3 сая, Орон нутгийн хөгжлийн сангийн дансанд 2,2 сая, Сум хөгжүүлэх сангийн дансанд 95,2 сая төгрөг байршиж байна.

Орон нутгийн ерөнхий орлогын дансанд 68,3 сая төгрөгийн үлдэгдэл байгаа нь орон нутгийн давсан орлогоос зарцуулагдаагүй 65,0 сая, төсөвт байгууллагуудын харилцах дансны төвлөрүүлсэн үлдэгдэл 3,3 сая төгрөг байна.

2.8.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 228,6 сая, эцсийн үлдэгдэл 153,2 сая төгрөг болж 75,3 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №2. Авлагын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	-	-	-
Байгууллагаас авах авлага	-	0,2	0,2
Татаас, санхүүжилтийн авлага	-	-	-
Зээлийн хүүгийн авлага	-	-	-
Бусад авлага	-	-	-
Зээлийн авлага	228,6	153,0	-75,6
Дүн	228,6	153,2	-75,4

Эх сурвалж: Баянцагаан сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын үлдэгдэлд 153,0 сая төгрөг нь СХС-ын зээлийн авлагын үлдэгдэл байна. Үүнээс 151,0 сая төгрөгийн 48-н зээлдэгчийн хэвийн зээл, 2,0 сая төгрөгийн 2 зээлдэгчийн хугацаа хэтэрсэн зээл байна.

2.8.3 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын эхний үлдэгдэл 205,9 сая, эцсийн үлдэгдэл 209,7 сая төгрөг болж, 3,7 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №3. Бараа материалын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалтын материал	36,67	46,32	9,65
Дуусаагүй үйлдвэрлэл	45,00	52,00	7,00
Бичиг хэргийн материал	0,95	2,13	1,17
Аж ахуйн материал	33,41	45,09	11,68
Түлш, шатах тослох материал	0,00	0,16	0,16
Барилгын засварын материал	1,14	0,85	-0,29
Бусад хангамжийн материал	43,85	27,30	-16,55
Мал амьтад	44,81	35,91	-8,9
Дүн	205,99	209,79	-3,89

Эх сурвалж: Баянцагаан сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

2.8.7 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 5337.8 сая, эцсийн үлдэгдэл 5669,8 сая төгрөг болж, 332,0 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №4. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга байгууламж, орон сууц	4246,50	4588,96	342,46
Тээврийн хэрэгсэл	188,78	178,18	-10,6
Машин тоног төхөөрөмж	405,13	398,93	6,2
Тавилга эд хогшил	188,89	204,57	15,68
Батлан хамгаалахын тоног төхөөрөмж	0,00	0,00	0,00
Түүх соёлын дурсгалт зүйл	0,10	0,10	0,00
Номын фонд	46,11	28,05	-18,06
Бусад үндсэн хөрөнгө	201,48	210,81	9,33
Программ хангамж	16,79	2,13	14,66
Бусад биет бус хөрөнгө	44,01	58,11	14,10
Дүн	5337,8	5669,9	332,1

Эх сурвалж: Баянцагаан сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд үндсэн хөрөнгө төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 117,9 сая, балансаас баланст шилжүүлэн авсан 14,1 сая, үнэ төлбөргүй хандиваар авсан 319,6 сая төгрөгөөр

нэмэгдсэн, балансаас баланст шилжүүлсэн 184,7 сая, акталсан 131,4 сая төгрөгөөр хасагдсан байна.

2.8.8 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 0.2 сая, эцсийн үлдэгдэл 16,9 сая төгрөг болж 16,6 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №5. Нийт өр төлбөрийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -	Дүнд эзлэх хувь
Богино хугацаат өр төлбөр дүн	0.2	16,9	16,7	100.0
Ажилчидтай холбогдсон өглөг	0.2	0.5	0.3	14.7
Байгууллагад төлөх өглөг	0.0	16,4	16,4	85.3
Урт хугацаат өр төлбөр дүн	-	-	-	-
Нийт дүн	0.2	16,9	16,7	100.0

Эх сурвалж: Баянцагаан сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд 16,7 сая төгрөгийн байгууллагад төлөх өглөг 16,4 сая төгрөг байна. Энэ нь 2019 онд тус сумын сургуулийн дотуур байрны их засварыг аймгийн ОНХС-аас 100,0 сая, сумын ОНХС-аас 40,0 сая, тухайн байгууллагын төсвөөс 16,4 сая төгрөгөөр санхүүжүүлэн хийгдэх байсан ба тухайн байгууллага тайлант онд тооцоог хийж чадаагүй бөгөөд сургуулийн тайланд өглөгөөр тусгасан нь голлох нөлөөг үзүүлж байна.

Хүснэгт 6. Өглөгийн үлдэгдэл байгууллагаар

Байгууллагын нэр	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Үүнээс		Зөрүү /өссөн+ /буурсан-/	Дүнд эзлэх хувь
			Байгууллагад төдөх	Ажиллагсдадтай холбоотой		
ИТХурал	-	-	-	-	0.00	0.0
ЗДТГазар	0.02	0.54	-	0.54	0.52	3.3
Баг	-	-	-	-	0.00	0
Сургууль	0.01	16.41	16.41	-	16.40	96.7
Цэцэрлэг	-	-	-	-	0.00	0
Соёл	0.26	-	-	-	-0.26	0
ЭМТөв	-	-	-	-	0.00	0
Сум хөгжүүлэх сан	-	-	-	-	0.00	0
Дүн	0.29	16.95	16.41	0.54	16.66	100.0

2.8.9 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 4245,6 сая, эцсийн үлдэгдэл 4419,2 сая төгрөг болж 173,6 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 7. ЗАСГИЙН ГАЗРЫН ХУВЬ ОРОЛЦОО /САЯ ТӨГРӨГ/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+/, бууралт -/	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2168,2	2168,2	0,0	0.0
Өмч /төрийн/	2168,2	2168,2	0.0	0.0
Хуримтлагдсан үр дүн	382,4	556,1	173,6	31.2
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1694,9	1694,9	0,0	0.0
Дүн	4245,5	4419,2	173,6	31.2

Эх сурвалж: Засгийн газрын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын оруулсан капитал данс өөрчлөлт нь тайлант оны хуримтлагдсан үр дүн 173,6 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

2.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Аймгийн ИТХ-ын 2019 оны төсөв батлах тухай 14/03 дугаар тогтоолд зааснаар Баянцагаан сумын Засаг дарга тайлант онд улсын төсөвт 3,5 сая, аймгийн төсөвт 120,6 сая нийт 124,1 сая төгрөгийн орлого оруулахаар батлагдсанаас гүйцэтгэлээр 139,2 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 112,1 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 8. Төвлөрүүлэх орлого

/сая төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1.Улсын төсөвт төвлөрүүлэх орлого	3,500.0	9,074.9	(5,574.9)	259.3
1.1.Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	1,700.0	7,118.4	(5,418.4)	418.7
1.2.Нэмэгдсэн өртгийн албан татвар	600.0	471.8	128.2	78.6
1.3.Агаарын бохирдлын төлбөр	1,200.0	1,484.7	(284.7)	123.7
2.Аймгийн орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлого	120,670.0	130,131.1	(9,461.1)	107.8
2.1.Цалин хөлс түүнтэй адилтгах орлогын албан татвар	105,000.0	108,565.0	(3,565.0)	103.4
2.2.Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	1,170.0	903.3	266.7	77.2
2.3.Газрын төлбөр	3,500.0	2,151.8	1,348.2	61.5
2.4.Авто тээвэр өөрөө явагч хэрэгслийн албан татвар	11,000.0	18,511.0	(7,511.0)	168.3
Нийт дүн	124,170.0	139,206.0	(15,036.0)	112.1

Улсын төсөвт төвлөрүүлэх орлого 5,5 сая төгрөгөөр давсан нь аж ахуй нэгжийн орлогын албан татвар төлөлтийг барагдуулах ажлыг үр дүнтэй зохион байгуулсантай холбоотой байна.

Аймгийн төсөвт төвлөрүүлэх орлого төлөвлөгөөнөөс 9,4 сая төгрөгөөр давж биелсэн нь цалин хөлс түүнтэй адилтгах орлогын албан татвар нэмэгдсэнтэй холбоотой уг татвар 3,5 сая төгрөгөөр, авто тээвэр өөрөө явагч хэрэгслийн албан татварын орлого 7,5 сая төгрөгөөр давж биелсэн нь голлох нөлөөг үзүүлж байна.

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2018 оны 03 тоот тогтоолоор сумд төвлөрөх татварын болон татварын бус орлогыг 53.7 сая төгрөгөөр баталснаас гүйцэтгэлээр 82.1 сая төгрөг төвлөрүүлж төлөвлөгөөг 152.8 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 9. Сумын орон нутгийн орлого

/сая төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1.Татварын орлого	108.1	159.8	51.7	143.7
ИОТХ	4.0	9.4	-5.4	187.1
Хадгаламжийн хүүгийн орлого	44.0	52.0	-8.0	120.8
Бууны татвар	4.0	3.9	0.1	102.0
Улсын тэмдэгтийн хураамж	1.5	19.1	-17.6	58.0
Ан агнуурын нөөцийн төлбөр	48.0	70.7	-22.7	135.4
Хог хаягдлын үйлчилгээний төлбөр	6.0	3.8	2.2	122.3
ТТАМАТөлбөр	0.3	0.3	0.0	233.3
Нохойны татвар	0.3	0.6	0.3	151.9
2.Татварын бус орлого	2.5	10.3	5.8	272.1
2.1.Хүү торгуулийн орлого	2.5	8.3	5.8	272.1
Нийт дүн	110.6	168.3	57.5	152.8

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 70105, 70106, 70503, 71602, 71702, 71801, 71802, 71806, 72101 гэсэн кодтой 9 хөтөлбөрт зориулан 2262,1 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 2100,7 сая төгрөгийг урсгал зардалд, 161,4 сая төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 577,9 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгээс, 1337,9 сая төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтээс, 144,4 сая төгрөгийг орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох санхүүжилтээс, 106,6 сая төгрөгийг үндсэн болох туслах үйл ажиллагааны орлогоос, 95,1 сая төгрөгийг урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилт, орон нутгийн төсвөөс авах санхүүжилт, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох санхүүжилтийг бүрэн авсан байна.

Үндсэн үйл ажиллагааны орлого 117,8 сая төгрөг бүрдүүлж, батлагдсан төсвөөс 11,8 сая төгрөгөөр давсан нь ан агнуурын орлогын төлөвлөгөө давсантай холбоотой байна.

Туслах үйл ажиллагааны орлого 0,4 сая төгрөг бүрдүүлж, батлагдсан төсвөөс 0,1 сая төгрөгөөр тасарсан нь ЗДТГ-ын өөрийн орлогын төлөвлөгөө тасарсантай холбоотой байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2159,9 сая төгрөг буюу 95,4 хувьтай байгаа нь сумын ерөнхий боловсролын сургуулийн цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал болон бусад зардал нийт 10.8 сая, цэцэрлэгийн нийгмийн даатгалын шитгэлийн зардал 0,8 сая, нормативт зардал нь 0,9 сая, хангамжийн материалын зардал нь 0,2 сая төгрөгөөр тус тус хэмнэгдсэн нь голлох нөлөөг үзүүлж байна.

Хүснэгт 10. Төсвийн гүйцэтгэл байгууллагаар сая.төг

Байгууллагын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Засаг даргын Тамгын газар	339,576.7	336,573.1	3,003.6	99.1
Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	80,776.5	80,556.2	220.3	99.7
Ерөнхий боловсролын сургууль	1,078,047.2	1,067,155.0	10,892.2	99.0
Цэцэрлэг	387,981.6	385,841.1	2,140.5	99.4
Эрүүл мэндийн төв	-	-	-	-
Соёлын төв	89,931.0	89,669.6	261.4	99.7
Орон нутгийн хөгжлийн сан	161,441.4	159,201.0	2,240.4	98.6
Сум хөгжүүлэх сан	124,405.5	41,001.3	83,404.2	33.0
Нийт дүн	2,262,159.9	2,159,997.3	102,162.6	95.5

Нэмэлт төсөв: Дээд шатны төсвийн захирагчаас 13,0 сая төгрөгийн нэмэлт бүрдүүлж бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжид 11,4 сая төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 1,5 сая төгрөгийн орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 11. Нэмэлт төсвийн судалгаа

Байгууллагын нэр	Санхүүжилт	Зарцуулалт	Төвлөрүүлсэн	
			Аймаг	Сум
Засаг даргын Тамгын газар	3,200.0	1,650.0		1,550.0
Иргэдийн төлөөлөгчдийн хурал	3,165.0	3,165.0		
Соёлын төв	1,778.0	1,770.0		8.0
Эрүүл мэндийн төв	-	-		
Сургууль	4,857.1	4,857.1		
Нийт дүн	13,000.1	11,442.1	-	1,558.0

2.10. ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ
Дараагийн аудитаар анхаар ч үзэх асуудал байхгүй байна.

2.11. Шилэн дансны мэдээлэл

д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд оруулсан	Хугацаа хоцроосон	Хугацаа болоогүй
1	Бүтэн жил	13	13	11		2
2	Хагас жил	3	3	2	1	
3	Улирал бүр	2	8	8		
4	Сар бүр	5	60	60		
5	Тухай бүр	6	72	59	13	
6	Нийт	29	156	140	14	2

Баянцагаан сумын Засаг дарга Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 140 мэдээллийг хугацаанд нь, 14 мэдээлэлд дахин завсар хийснээс хугацаа хоцроосон төлөвтэй болж 2 мэдээллийг байршуулах хугацаа болоогүй байна.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар акт, албан шаардлага зөвлөмж өгөөгүй байна.

2.13. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Баянцагаан сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Баянцагаан сумын Засаг даргын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн мөнгөн гүйлгээ, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.3 дахь заалт, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Баянцагаан сумын Засаг даргын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн нэгтгэсэн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 БАЙГУУЛЛАГЫН ҮНДСЭН АЖИЛЛАГААТАЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ

3.1.1 Аудитад хамрагдсан төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 37,8 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 1,3 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 36,3 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага, 0,2 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгсөн байна.

Үүнээс: Сумын ЗДТГ-ын хөрөнгийн бүртгэлд байгаа автомашины эзэмшлийн гэрчилгээ байгууллагын жолооч Г.Рэнцэнжүгдэрийн нэр нэр дээр бүртгэлтэй, багийн дарга нарын 5 ш мотоциль нь эзэмшлийн гэрчилгээгүй байна. Мөн сургуулийн захирлын тушаалаар сахилгын шийтгэлтэй байгаа албан хаагчдад үр дүнгийн мөнгөн урамшуулал олгосон, сумын ИТХ-ын НДШ-н мэдээгээр илүү төлөлттэй байхад авлагаар тусгаагүй зэрэг алдаа зөрчил илэрсэн байна.

3.1.2 Эрсдэл: Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн тайлан үнэн зөв нэгтгэгдэхгүй байх, төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах, хөрөнгө шамшигдуулах.

3.1.3 Өгсөн зөвлөмж: Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын төсвийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах, Төсвийн тухай хуульд заасан эрхээ бүрэн хэрэгжүүлж ажиллах, цаашид харьяа байгууллагуудын гаргасан алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг 2020 оны 06 дугаар сарын 1-ний дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	534372682.14	528936826.07
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	99753088.37	165875999.36
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	99753088.37	165875999.36
3121	Төгрөг	99753088.37	165875999.36
31211	Төрийн сангийн харилцах	99753088.37	165875999.36
33	АВЛАГА	228,628,161.00	153,269,930.00
335	Бусад авлага	0.00	207944.00
3351	Байгууллагаас авах авлага	0.00	207944.00
336	Зээлийн авлага	228628161.00	153061986.00
3361	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага	228628161.00	153061986.00
33612	Хувь хүмүүст олгосон зээл	228628161.00	153061986.00
35	БАРАА МАТЕРИАЛ	205991432.77	209790896.71
351	Түүхий эд материал	36667725.40	46327905.40
35110	Тусгай зориулалттай материал	36667725.40	46327905.40
35200	Дуусаагүй үйлдвэрлэл	45000000.00	52000000.00
354	Хангамжийн материал	79507707.37	75547932.49
35410	Бичиг хэргийн материал	958800.00	2134800.00
35420	Аж ахуйн материал	33415538.76	45093580.76
35440	Түлш, шатах тослох материал		165000.00
35450	Барилгын засварын материал	1148000.00	850000.00
35470	Бусад хангамжийн материал	43985368.61	27304551.73
35600	Мал амьтад	44816000.00	35915058.82
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3711565527.30	3907281091.43
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3711565527.30	3907281091.43
392	Биег хөрөнгө	3653430527.30	3848896091.43
39201	Барилга, байгууламж, орон сууц	4246505177.74	4588966743.86
39202	Хуримтлагдсан элэгдэл	1095060789.11	1209708683.47
39203	Авто-тээврийн хэрэгсэл	188786204.68	178184244.68
39204	Хуримтлагдсан элэгдэл	81675281.04	94365188.56
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	405137690.66	398936293.20
39206	Хуримтлагдсан элэгдэл	240517626.61	252155729.32
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	188899015.37	204575305.47
39208	Хуримтлагдсан элэгдэл	122998349.02	108372542.38
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	106340.00	106340.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	201484101.67	210819001.67
39215	Хуримтлагдсан элэгдэл	83351403.29	96145823.66
39217	Ном	46115446.25	28056129.94
393	Биег бус хөрөнгө	58135000.00	58385000.00
39301	Программ хангамж	16790000.00	2130000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	2665000.00	1855000.00

39303	Бусад биет бус хөрөнгө	44010000.00	58110000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	4245938209.44	4436217917.50
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	289163.00	16946421.17
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	289163.00	16946421.17
413	Өглөг	289163.00	16946421.17
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	289163.00	538093.17
4136	Бусад өглөг	0.00	16408328.00
41361	Байгууллагад төлөх өглөг		16408328.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	4245649046.44	4419271496.33
51	Засгийн газрын хувь оролцоо	4,245,649,046.44	4,419,271,496.33
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,168,230,867.03	2,168,230,867.03
51101	Өмч: - төрийн	2,168,230,867.03	2,168,230,867.03
512	Хуримтлагдсан үр дүн	382,477,946.11	556,100,395.99
51210	Өмнөх үеийн үр дүн	841,150,472.25	382,477,946.11
51220	Тайлант үеийн үр дүн	(458,672,526.14)	173,622,449.88
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,694,940,233.30	1,694,940,233.31
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	4245938209.44	4436217917.50

4.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан
2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

